

БАТЛАВ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

..... оны ..... сарын ..... өдөр

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ - 2016 ОН**  
(IX-XII сар)

2016.09.04

Улаанбаатар хот

Хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		Хариуцах нэгжийн нэр
	Арга хэмжээний шалгуур үзүүлэлт (тоо, чанар хугацаа)-ийн хүрэх түвшин	Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	
1	2	3	4
<b>Нэг. “Төрийн өмчийн талаар хууль тогтоомж, бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах удирдлага, зохицуулалтаар хангах” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b>			
<b>ХӨТӨЛБӨР I</b> <b>“Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль, эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах” хөтөлбөрийн хүрээнд:</b>			
<b>Арга хэмжээ 1.1.1.</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрын захирлуудыг чөлөөлж, томилох асуудлыг шийдвэрлүүлэх	<ul style="list-style-type: none"><li>- Гүйцэтгэх захирал, захирлаар томилогдохоор нэр дэвшигчдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулан АТГ-аар хянуулсан байх,</li><li>- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал, шийдвэрийн төсөл, танилцуулгыг боловсруулан бэлтгэсэн байх,</li><li>- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хуралдаан (Газрын хуралдаан)-ы шийдвэр албажсан байх,</li><li>- Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж, чиглэл өгсөн байх,</li><li>- X-XII сард.</li></ul>	Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн удирдлагыг Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс чөлөөлж, томилсон шийдвэр гарсан байна. Төрийн өмчит үйлдвэрийн газрын удирдлагын ажлыг хүлээлцсэн байна.	Бодлого, төлөвлөлт, удирдлагын хэлтэс (БТУХ), Захиргаа, хууль зүйн хэлтэс (ЗХЗХ)

<p><b>Арга хэмжээ 1.2.2.</b> Томилогдсон захирлуудтай хөлсөөр ажиллах гэрээ, контрактын гэрээ байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Захирлуудтай хөлсөөр ажиллах гэрээ, контрактын гэрээний төслийг хууль эрх зүйд нийцүүлэн боловсруулсан байх,</li> <li>- Гэрээ байгуулсан байх,</li> <li>- Тухай бүр.</li> </ul>	<p>Хууль журамд нийцсэн гэрээ, контракт байгуулсан байна.</p>	<p>БТУХ, ЗХЗХ</p>
<p><b>Арга хэмжээ 1.3.3</b> Төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ)-ын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчит үйлдвэрийн газруудын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, дүрмийн төслийг боловсруулах,</li> <li>- Хууль, эрх зүйд нийцүүлэх,</li> <li>- Холбогдох этгээдээс санал авч тусгах,</li> <li>- Газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг бэлтгэх,</li> <li>- Газрын хуралдааны шийдвэрээр батлуулсан байх,</li> <li>- X-XII сард.</li> </ul>	<p>Төрийн өмчит үйлдвэрийн газрууд үр ашигтай ажиллах боломжтой болсон байна.</p>	<p>БТУХ, ЗХЗХ</p>
<p><b>Арга хэмжээ 1.4.4.</b> Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл, жагсаалт боловсруулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хувьчлах, өөрчлөн байгуулах аж ахуйн нэгжийн судалгаа гаргах,</li> <li>- Танилцуулга бэлтгэж, удирдлага, газрын хуралдаанд танилцуулах,</li> <li>- Үндсэн чиглэлийг УИХ-аар батлуулах арга хэмжээ авах,</li> <li>- 2017-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт боловсруулах,</li> <li>- Жагсаалтыг Засгийн газрын тогтоолоор батлуулах,</li> <li>- XI сард.</li> </ul>	<p>Төрийн өмчийн ашиглалт, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэнэ.</p>	<p>БТУХ, ЗХЗХ</p>
<p><b>Арга хэмжээ 1.5.5.</b> Аймаг, нийслэл дэх орон сууц хувьчлах товчооны ажиллах журмын төслийг боловсруулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Журмын төслийг боловсруулах,</li> <li>- Төслийг цахим хуудсанд байршуулж, олон нийтийн зүгээс танилцаж, санал өгөх боломж бүрдүүлэх,</li> <li>- Журмын төсөлд аймаг, нийслэлийн Засаг даргаас санал авах,</li> <li>- Саналыг нэгтгэн боловсуулж, төсөлд тусгах,</li> <li>- Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах арга хэмжээ авах,</li> <li>- XII сард.</li> </ul>	<p>Орон сууц хувьчлах ажлыг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулах эрх зүйн орчин тодорхой болно.</p>	<p>БТУХ, ЗХЗХ</p>
<p><b>Арга хэмжээ 1.6.6.</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн судалгааг шинэчлэн гаргаж, дүгнэлт хийх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага болон ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлсний судалгаа хийх,</li> <li>- Гүйцэтгэх захирал, захирлуудын судалгааг шинэчлэх,</li> <li>- Эдийн засгийн үзүүлэлтийн судалгаа хийх,</li> <li>- ТУЗ-ийн бүрэлдэхүүний судалгааг шинэчлэн гаргах,</li> <li>- Хийсэн судалгаанд дүгнэлт хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох,</li> </ul>	<p>Төрийн өмчийн бодлого, удирдлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгаа, шинжилгээний дүн, дүгнэлттэй болно.</p>	<p>БТУХ</p>

	- XI-XII сард.		
<b>Арга хэмжээ 1.7.7.</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох ногдол ашгийг төвлөрүүлэх	- Төрд ногдох ногдол ашгийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангах, - Ногдол ашгийг төвлөрүүлэх тооцоо судалгааг хийж, газрын хуралдаанаар батлуулах, - X-XII сард.	2015 жилийн эцэст ашигтай ажиллаж байгаа 39 компанийн цэвэр ашгаас 7,0 тэрбум төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.	БТУХ
<b>Арга хэмжээ 1.8.8.</b> Төрийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд өгсөн удирдамжийн биелэлтийг гаргах	- Төлөөлөн удирдах зөвлөлүүдээс удирдамжийн биелэлтийг хүлээн авч, нэгтгэн дүгнэх, - Удирдамжийн биелэлтэд нэгдсэн дүгнэлт гарган, танилцуулга бэлтгэх, - Газрын хуралдаанд танилцуулах, - XII сард.	Газрын хуралдааны шийдвэрийн биелэлт хангагдсан байна.	БТУХ
<b>ХӨТӨЛБӨР II</b> “Төрийн болон орон нутгийн өмчийн бодлого, удирдлагын оновчтой хэлбэрийг хэрэгжүүлж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг сайжруулан үр ашгийг дээшлүүлэх, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд:			
<b>Арга хэмжээ 2.1.9.</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хувьцаат компаниудын 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулах	- Компаниудын 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан байх, - Ажлын хэсэг байгуулж, ТУЗ-ийн баталсан зорилтот түвшин, төлөвлөгөөг хэлэлцэж, газрын хуралдаанд оруулахад бэлтгэх, - Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах, - XII сард.	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хувьцаат компаниудын 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө хэрэгжүүлж ажиллах боломжтой болно.	БТУХ
<b>Арга хэмжээ 2.2.10.</b> Зарим төрийн өмчит үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах арга хэмжээ авах	- Өөрчлөн байгуулах ТӨҮГ-ын жагсаалт, үндэслэл, судалгааг гаргах, - Компанийн хэлбэрт шилжүүлэх асуудлыг боловсруулах, - Тогтоолын төсөл, танилцуулга бэлтгэх, - Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, - XI-XII сард.	Алдагдалтай, ашиггүй ажиллаж байгаа ТӨҮГ-уудын менежмент сайжирч, ашигтай ажиллах боломж бүрдэнэ.	БТУХ
<b>Арга хэмжээ 2.3.11.</b> Эрчим хүчний, замын болон бусад компаниудын төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх нэр дэвшигчдийг томилж, ТУЗ-ийг шинэчлэх	- Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэхээр нэр дэвшигчдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулсан байх, - Газрын хуралдаанаар ТУЗ-ийн шинэчилсэн бүрэлдэхүүнийг томилсон шийдвэр гаргуулах, - Төрийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд арга зүйн зөвлөмж хүргүүлж, бодлого, чиглэлээр хангаж ажиллах, - IX-XII сард.	Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журмын дагуу ТУЗ-үүд шинэчлэгдэн ТУЗ-ийн дарга, компанийн гүйцэтгэх захирлууд томилогдсон байна.	БТУХ, ЗХЗХ
<b>Арга хэмжээ 2.4.12.</b> Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат	- Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд тавигдах шаардлага, болзлыг боловсруулах,	Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын	БТУХ

бус гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр шинэчлэн томилох	<ul style="list-style-type: none"> <li>- Сонгон шалгаруулалтаар шалгарсан өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр ТУЗ-ийн хараат бус гишүүнээр нэр дэвшигчийг сонгон шалгаруулах зарыг олон нийтэд түгээх, болзол, шаардлагыг сурталчлах,</li> <li>- Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, хараат бус гишүүдийг сонгон томилох,</li> <li>- XII сард.</li> </ul>	ТУЗ-үүдийн бүтэц, бүрэлдэхүүн бүрэн шинэчлэгдсэн байна.	
<b>Хоёр. “Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хамгаалалттай холбоотой бүртгэл, тооллого явуулах, төрийн өмчийн бүрэн бүтэн байдал, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт тавих”</b> гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:			
<b>ХӨТӨЛБӨР III</b> <b>“Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг боловсронгуй болгож, өмчийн улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэн баяжуулж, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хөдөлгөөнийг зохицуулах”</b> хөтөлбөрийн хүрээнд:			
<b>Арга хэмжээ 3.1.13.</b> Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх “Түрээсийн гэрээний загвар”, жишиг үнийг шинэчлэн боловсруулж, батлуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Түрээсийн гэрээний загвар, жишиг үнийн саналын төсөл боловсруулах,</li> <li>- Газрын хуралдаанаар оруулах асуудлыг бэлтгэж, хэлэлцүүлэн батлуулах,</li> <li>- Батлагдсан гэрээний загвар, жишиг үнийг цахим хуудсанд байршуулан олон нийтэд ил тод мэдээлэх,</li> <li>- X сард.</li> </ul>	Төрийн өмчийн илүүдэл зай, талбайг түрээслүүлэх замаар төсвийн орлогыг бүрдүүлнэ. Түрээсийн орлогоос төрийн өмчит хуулийн этгээдийн зардлыг санхүүжүүлнэ.	Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (ТӨБХХ)
<b>Арга хэмжээ 3.2.14.</b> Төрийн өмчийн эд хөрөнгийн дуудлага худалдааны баримт бичгүүдийн загвар маягыг боловсруулан батлуулах	<ul style="list-style-type: none"> <li>- “Нээлттэй дуудлагын худалдааны зар”, “Дуудлагын худалдаанд оролцох хүсэлт”, “Дуудлагын худалдааны тэмдэглэл”-ийн маягт, “Дуудлагаар худалдсан хөрөнгийн худалдах, худалдан авах гэрээ”-ний загварыг боловсруулах,</li> <li>- Маягт, загварыг газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байх,</li> <li>- Батлагдсан маягт, загварыг цахим хуудсанд байршуулан олон нийтэд ил тод мэдээлэх,</li> <li>- XI сард.</li> </ul>	Дуудлага худалдааг зохион байгуулахад шаардлагатай баримт бичгийн нэгдсэн стандарт бий болж, оролцогчдод үзүүлэх үйлчилгээ чирэгдэлгүй, хялбар болно.	ТӨБХХ
<b>Арга хэмжээ 3.3.15.</b> Стратегийн судалгааны хүрээлэнгийн барилга, дагалдах хөрөнгийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэх арга хэмжээ авах	<ul style="list-style-type: none"> <li>- Шилжүүлэх хөрөнгийн жагсаалтыг гаргаж, данс бүртгэлтэй тулгалт хийх,</li> <li>- Хөрөнгө шилжүүлэх шийдвэрийн төсөл боловсруулах,</li> <li>- Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулсан байх,</li> <li>- XI сард.</li> </ul>	Засгийн газрын 2016 оны 85 дугаар тогтоол хэрэгжсэн байна.	ТӨБХХ
<b>Арга хэмжээ 3.4.16.</b> Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллого хийж дуусгах, дүн мэдээг нэгтгэх	<ul style="list-style-type: none"> <li>- Үзлэг тооллогыг хийж дуусгах,</li> <li>- Дүн мэдээг аймаг, сум, салбар, нэгж бүрээр гаргах,</li> <li>- Улсын нэгтгэлд хуваарийн дагуу нэгтгэн боловсруулалт хийх,</li> </ul>	Бүх нэгжийг хамруулан дүн мэдээг нэгтгэн боловсруулсан байна.	ТӨБХХ

	- IX-XI сард.		
<b>Арга хэмжээ 3.5.17.</b> Төрийн болон орон нутгийн үзлэг тооллогын дүн мэдээнд дүн шинжилгээ хийж, Засгийн газар, УИХ-д танилцуулахад бэлтгэх	- Дүнг 13 төрлийн маягт тус бүрээр нэгтгэх, - Нэгтгэсэн дүнд үндэслэн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, - Улсын үзлэг тооллогын нэгдсэн дүнгийн талаар танилцуулга бэлтгэх, - Танилцуулгыг яам тус бүрээр салгаж, товхимол болгох, - Шийдвэрийн төсөл, цаашид авах арга хэмжээг боловсруулах, - XI-XII сард.	Улсын үзлэг тооллогын үр дүнд төрийн өмчийн бүртгэл-мэдээлэл шинэчлэгдсэн байна.	ТӨБХХ
<b>Арга хэмжээ 3.6.18.</b> Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасах, балансаас балансад шилжүүлэх, үндсэн хөрөнгө, машин тоног төхөөрөмж худалдан авах зөвшөөрөл олгох, төрийн өөрийн өмчид оруулсан хөрөнгө оруулалтыг баталгаажуулах санал боловсруулж шийдвэрлүүлэх	- Санал боловсруулах, - Газрын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлэх, - Шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах, - XI-XII сард.	Төрийн өмчийн ашиглалт, үр өгөөж сайжирна.	ТӨБХХ
<b>Арга хэмжээ 3.7.19.</b> Засгийн газрын тогтоолын дагуу зарим яам, агентлагийг татан буулгах, шинээр байгуулах хүрээнд хаалтын болон эхлэлтийн тайлан тэнцэл гаргах, холбогдох хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, өр төлбөр, авлагыг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх	- Хаалтын болон эхлэлтийн тайлан тэнцэл гарсан байх, - Хөрөнгө шилжүүлэх шийдвэрийн төсөл боловсруулах, - Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулсан байх, - X-XI сард.	УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, ерөнхий бүдүүвч”-ийн дагуу Засгийн газраас авсан арга хэмжээний хэрэгжилт хангагдана.	ТӨБХХ
<b>Арга хэмжээ 3.8.20.</b> Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээг баталгаажуулж, гэрээний төлбөрийг төлүүлэх арга хэмжээ авах	- Хөрөнгө түрээсэлж буй байгууллага, түрээсийн гэрээний судалгааг гаргах, - Төлбөр төлсөн байдалд судалгаа хийх, - Түрээсийн төлбөрийн орлогод хяналт тавих, - IX-XII сард.	Түрээсийн төлбөрийн 20 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх замаар улсын төсвийн орлогыг бүрдүүлнэ.	ТӨБХХ
<b>ХӨТӨЛБӨР IY</b> “Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалтын үр өгөөжид мониторинг хийх, өмчийн болон санхүүгийн хяналт шалгалтын үр дүнг сайжруулах” хөтөлбөрийн хүрээнд:			
<b>Арга хэмжээ 4.1.21.</b> Төрийн болон төрийн өмчийн	- Хугацаа, хуваарийг тусгасан төлөвлөгөө боловсруулан батлуулах, IX сард	Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулах	ТӨБХХ

<p>оролцоотой хуулийн этгээдийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төлөвлөгөөнд тусгагдсан хяналт шалгалтыг тусгайлсан удирдамжаар гүйцэтгэх,</li> <li>- Хяналт шалгалтын ажлын хүрээнд Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд эдийн засгийн дүн шинжилгээ хийх,</li> <li>- Хяналт шалгалтын дүн, эдийн засгийн дүн шинжилгээний дүгнэлтийн талаар танилцуулга бэлтгэх,</li> <li>- Газрын хуралдаанд танилцуулах асуудлыг боловсруулах, шийдвэрийн төсөл боловсруулах,</li> <li>- IX-XII сард, тухай бүрд.</li> </ul>	<p>асуудалд холбогдох хууль тогтоомж, заавар журмыг хэрэгжүүлсэн байна.</p>	
<p><b>Арга хэмжээ 4.2.22.</b> Шалгалтын дүн мэдээг нэгтгэн, зөрчил доголдол, түүнийг арилгах талаар гарсан тогтоол, шийдвэрийн биелэлтийг тооцох</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Шалгалтад хамрагдсан бүх байгууллага, ААН-д өгсөн зөвлөмж, чиглэлд тусгагдсан асуудлын судалгаа гаргах,</li> <li>- Шийдвэр, зөвлөмж, чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг нэгтгэн гаргах,</li> <li>- Дүгнэлт, танилцуулга, мэдээлэл бэлтгэх,</li> <li>- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх,</li> <li>- XII сард.</li> </ul>	<p>Шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, зөвлөмж, чиглэл хэрэгжсэн байна.</p>	<p>ТӨБХХ</p>
<p><b>Арга хэмжээ 4.3.23.</b> Төрийн өмчит хуулийн этгээдийн ашиглаж байсан илүүдэлтэй автомашиныг шинээр байгуулагдсан яам, агентлаг болон бусад төрийн өмчит байгууллагад шилжүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Судалгаа, тоо баримт, тооцоо гаргах,</li> <li>- Балансаас балансад шилжүүлэх асуудлын төсөл боловсруулах,</li> <li>- Газрын хуралдаанд танилцуулан шийдвэр гаргуулах,</li> <li>- IX-XI сард.</li> </ul>	<p>Засгийн газраас өгсөн саналын дагуу хуваарилж шийдвэрлэсэн байна.</p>	<p>ТӨБХХ</p>
<p><b>Гурав. “Худалдан авах ажиллагааг төлөвлөн батлагдсан төсвийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулах, тайлагнах” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b></p>			
<p><b>ХӨТӨЛБӨР Ү</b></p>			
<p><b>“Худалдан авах ажиллагааны хууль эрх зүйн орчны сайжруулж, олон улсын хөгжлийн чиг хандлагыг судлан, худалдан авах ажиллагааны чадавхийг бэхжүүлэн цахим худалдан авах ажиллагааг боловсронгуй болгох” хөтөлбөрийн хүрээнд:</b></p>			
<p><b>Арга хэмжээ 5.1.24.</b> Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон гадаадын бусад донор байгууллагуудтай худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хамтран ажиллах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Дэлхийн банкны санхүүжилтээр “Ухаалаг засаг” төслийн хүрээнд хийгдэх 2 ажлын худалдан авах ажиллагааг үргэлжлүүлэн зохион байгуулах эсэх талаар Дэлхийн банкны төслийн багтай уулзалт зохион байгуулах,</li> <li>- Цаашид хамтран ажиллах тухай албан бичиг төлөвлөн, хүргүүлэх,</li> <li>- IX/15-ны дотор.</li> </ul>	<p>Гадаадын хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний худалдан авалт бүрэн хийгдсэн байна.</p>	<p>Худалдан авах ажиллагааны хэлтэс (ХААХ)</p>
<p><b>Арга хэмжээ 5.2.25.</b> ТӨБЗГ-т 2017 онд зохион байгуулах улсын болон бүсийн чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Захиалагчаас санал авч нэгтгэх,</li> <li>- Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгах,</li> <li>- Засгийн газрын шийдвэр, жагсаалтын төсөл</li> </ul>	<p>Хуулийн хугацаанд багтаан жагсаалтыг батлуулсан байна.</p>	<p>ХААХ</p>

ажиллагаа, Ерөнхий гэрээгээр 2017 онд худалдан авах барааны жагсаалтыг Засгийн газрын тогтоолоор батлуулах	<ul style="list-style-type: none"> <li>боловсруулах,</li> <li>- Засгийн газрын хуралдаанд оруулж, батлуулах,</li> <li>- XI сард.</li> </ul>		
<b>Арга хэмжээ 5.3.26.</b> 2017 онд ТӨБЗГ-т зохион байгуулах худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Батлагдсан жагсаалтад тусгагдсан төсөл, арга хэмжээ бүрийг тусгасан тухайн Төсвийн ерөнхийлөн захирагч нар, ТӨБЗГ-ын хамтарсан төлөвлөгөө батлах,</li> <li>- 2017 онд ТӨБЗГ-аас зохион байгуулах худалдан авах ажиллагааны Ерөнхий төлөвлөгөөг Ерөнхий сайдаар батлуулсан байх,</li> <li>- XI сард.</li> </ul>	Хуулийн хугацаанд багтаан хэрэгжүүлсэн байна.	ХААХ
<b>Арга хэмжээ 5.4.27.</b> Аймаг, нийслэл, дүүргүүдэд цахим худалдан авах ажиллагааны системийн сургалт, Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалт зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалт зохион байгуулах чиглэл өгөх,</li> <li>- Бэлтгэл хангуулах,</li> <li>- Сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа хийх,</li> <li>- Судалгааны дагуу олон улсын байгууллагын санхүүжилтээр Сангийн яам, ТББ-тай хамтран сургалт зохион байгуулах,</li> <li>- Онлайн болон бусад хэлбэрээр шалгалт авч, гэрчилгээ олгох,</li> <li>- XI-XII сард, 8 удаа.</li> </ul>	Орон нутагт худалдан авах ажиллагаа зохион байгуулах чадавхи дээшилнэ.	ХААХ, ЗХЗХ, МТА (Мэдээллийн технологийн алба)
<b>ХӨТӨЛБӨР ҮІ</b>			
<b>“Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулж, мэдээллийн санг бүрдүүлэн баяжуулах” хөтөлбөрийн хүрээнд:</b>			
<b>Арга хэмжээ 6.1.28</b> Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 2, 3 дугаар хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Үнэлгээний хороо байгуулах,</li> <li>- Худалдан авах ажиллагааг зохион байгуулах,</li> <li>- Шаардлагад нийцсэн тендерт оролцогчтой хуулийн хугацаанд гэрээ байгуулах,</li> <li>- Тендер шалгаруулалтын ил тод байдлыг хангаж ажиллах,</li> <li>- XII/20-ны дотор.</li> </ul>	Худалдан авах ажиллагаа хуулийн хугацаанд зохион байгуулагдсан байна.	ХААХ
<b>Арга хэмжээ 6.2.29.</b> Тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Гэрээ байгуулсан ажлын үр дүнг тухай бүр цахим хуудсанд нийтлэх,</li> <li>- Гэрээ байгуулсан ААН-үүдийн бүртгэлийг байгууллагын цахим хуудсанд ил тод байршуулах,</li> <li>- Худалдан авах ажиллагааны явц, үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх,</li> <li>- XII/20-ны дотор.</li> </ul>	Худалдан авах ажиллагааны нээлттэй байдал хангагдсан байна.	ХААХ
<b>Арга хэмжээ 6.3.30.</b> 2017 онд Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа бүтээгдэхүүнийг тодорхойлох, эрэлт нийлүүлэлтийн	<ul style="list-style-type: none"> <li>- Орон нутаг, дүүргээс 2017 онд ерөнхий гэрээгээр худалдан авах бараа бүтээгдэхүүний судалгааг гаргуулан авах,</li> <li>- Судалгааг нэгтгэн, дүгнэлт гаргах,</li> </ul>	2017 онд ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, бүтээгдэхүүний нэр төрөл тодорхой болсон байна.	ХААХ

судалгааг 21 аймаг, дүүргээс авч нэгтгэх	<ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, бүтээгдэхүүний нэр төрлийг тодорхойлж, тооцоо, дүгнэлт, танилцуулга бэлтгэх,</li> <li>- 2017 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтад тусгах арга хэмжээ авах,</li> <li>- IX-XII сард.</li> </ul>		
<b>Арга хэмжээ 6.4.31.</b> Орон нутгийн худалдан авах ажиллагааны 3, 4-р улирлын тайлан хүлээн авах, нэгтгэх	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээ нэгтгэх,</li> <li>- Удирдлагад танилцуулах,</li> <li>- Мэдээ, мэдээлэл, тайланд оруулж, тайлагнан мэдээлэх,</li> <li>- X/15, XII/25.</li> </ul>	Орон нутагт зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны үр дүнгийн мэдээлэл тодорхой болно.	ЗХЗХ
<b>Дөрөв. “Захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээлэл, технологийн хөгжлийг хангах” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b>			
<b>ХӨТӨЛБӨР VII</b>			
<b>“Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаа, худалдан авах ажиллагаанд хууль эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, бүтцийн нэгжүүдийн уялдаа холбоог хангаж, захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд:</b>			
<b>Арга хэмжээ 7.1.32.</b> Агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг боловсруулан батлуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Төслийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах,</li> <li>- Ерөнхий сайдын захирамжийн төсөл боловсруулах,</li> <li>- Хөтөлбөрийг батлуулж, байгууллагын нийт албан хаагчид болон олон нийтэд ил тод мэдээлэх,</li> <li>- IX/05-ны дотор.</li> </ul>	Байгууллагын үйл ажиллагааны зорилго, чиглэл тодорхой болсон байна.	ЗХЗХ
<b>Арга хэмжээ 7.2.33.</b> Байгууллагын албан хаагчдыг томилсон шийдвэрийг эцэслэн гаргаж танилцуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль тогтоомжид нийцсэн байх,</li> <li>- АТГ-аас ирүүлсэн дүгнэлтийг үндэслэсэн байх,</li> <li>- Албан хаагчдад шийдвэр, ажлын байрны тодорхойлолтыг танилцуулан мэдээлэх,</li> <li>- IX/06-ны дотор.</li> </ul>	Байгууллагын бүтэц орон тоонд ажиллах албан хаагчид томилогдож, байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэн байна.	ЗХЗХ
<b>Арга хэмжээ 7.3.34.</b> Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг боловсруулан батлуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Дотоод журмыг боловсруулах ажлын хэсгийг байгуулах,</li> <li>- Журмын төслийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах,</li> <li>- Төсөлд нийт албан хаагчдаас санал авах,</li> <li>- Албан хаагчдын саналыг тусган эцэслэн боловсруулж, батлуулах,</li> <li>- Нийт албан хаагчдад танилцуулан, ил тод мэдээлэх,</li> <li>- IX сард.</li> </ul>	Байгууллагын хөдөлмөрийн дотоод зохион байгуулалт, хөдөлмөрийн харилцааны эрх зүйн зохицуулалт хууль нийцэж, хэм хэмжээ тодорхой болсон байна.	ЗХЗХ
<b>Арга хэмжээ 7.4.35.</b> “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”-ийг боловсруулан мөрдөж эхлүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Дэгийн төслийг боловсруулж, албан хаагчид, хурлын орон тооны бус гишүүдээс санал авах,</li> <li>- Саналыг төсөлд тусган эцэслэн боловсруулах, шийдвэрийн төслийг бэлтгэх,</li> <li>- Газрын хуралдаанд танилцуулах, батлуулах,</li> <li>- Албан хаагчид, олон нийтэд танилцуулах арга хэмжээ авах,</li> </ul>	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаан дэг журамтай, цэгцтэй зохион байгуулагдана.	ЗХЗХ



	- XII/10-ны дотор.		
<b>Арга хэмжээ 7.5.36.</b> Байгууллагын архив, албан хэрэг хөтлөх зааврын төслийг боловсруулж, батлуулах	- Ажлын хэсэг байгуулах, - Зааврын төслийг хууль тогтоомж, эрх зүйн актад нийцүүлэн боловсруулах, - Зааврын төсөлд нийт албан хаагчдаас санал авч, тусган батлуулах, - Албан хаагчдад танилцуулан мөрдүүлэх, - XII/20-ны дотор.	Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандарт хэвшиж, төрийн ажлын зохион байгуулалт, эмх цэгц сайжирч, байгууллагын соёл төлөвшинө.	ЗХЗХ
<b>Арга хэмжээ 7.6.37.</b> Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулах	- Хэлтсүүдээс санал авч, нэгтгэн боловсруулах, - Саналын төслийг удирдлагад танилцуулж, Ерөнхий сайдын ажлын албанд хүргүүлэх, - Х сард.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхой болсон байна.	ЗХЗХ, Бүх хэлтэс, алба
<b>Арга хэмжээ 7.7.38.</b> Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгах саналыг боловсруулах	- Хэлтсүүдээс санал авч, нэгтгэн боловсруулах, - Саналын төслийг удирдлагад танилцуулж, Сангийн яаманд хүргүүлэх, - Х сард.	2017 онд хэрэгжүүлэх үндсэн чиглэлд тодорхой асуудал тусгагдсан байна.	ЗХЗХ, Бүх хэлтэс, алба
<b>Арга хэмжээ 7.8.39.</b> Хууль, шүүхийн байгууллагад үүссэн хэрэг, маргаанд байгууллагыг төлөөлж нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцох, тайлбар мэдүүлэг, нотлох баримт гаргаж өгөх	- Тухайн хэрэг, маргаантай холбогдох албан хаагчидтай хамтран ажиллах, - Хуулийн хүрээнд хэрэг, маргааныг шийдвэрлүүлсэн байх, - Удирдлагад танилцуулах, - IX-XII сард.	Хэрэг, маргааны шийдвэрлэлт ахисан байна.	ЗХЗХ
<b>Арга хэмжээ 7.9.40.</b> Албан бичиг, эрх зүйн болон захиргааны акт, хурлаар хэлэлцүүлэх асуудлын төслийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянах	- Төслийг хянаж, хууль зүйд нийцүүлэх арга хэмжээ авах, - Хянасан бичиг, эрх зүйн актын бүртгэл хөтлөх, - Өдөр тутамд.	Хуульд нийцсэн албан бичиг, эрх зүйн акт албажсан байх	ЗХЗХ
<b>Арга хэмжээ 7.10.41.</b> Нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг боловсруулж, батлуулах	- Жагсаалтын төсөлд Тагнуулын байгууллагаас санал авах, - Жагсаалтыг батлуулан мөрдөх, - XII/10-ны дотор.	Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	ЗХЗХ
<b>Арга хэмжээ 7.11.42.</b> Орон нутгийн өмчийн газар байгуулагдахад дэмжлэг үзүүлж, зөвлөмж, чиглэл өгөх	- Хууль тогтоомж, "Агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-г нийцүүлэн зөвлөмж, чиглэл боловсруулах, - Албажуулж, орон нутгийн нэгжүүдэд хүргүүлэх, - IX, XII сард.	Орон нутгийн өмчийн газрыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангасан байна.	ЗХЗХ, ТӨБХХ
<b>Арга хэмжээ 47.12.43.</b> Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал боловсруулж,	- Санал боловсруулж, удирдлагын түвшинд танилцуулах, - Олон улсын байгууллага, холбогдох бусад байгууллагатай холбогдох,	Гадаад хамтын ажиллагаа өргөжинө. Гадаадын ижил төстэй байгууллагын туршлагыг судлах,	ЗХЗХ, Бусад хэлтэс, алба

хэрэгжүүлэх арга хэмжээ авах	- IX-XII сард.	байгууллагын чадавхийг сайжруулах боломж бүрдэнэ.	
<b>Арга хэмжээ 7.13.44.</b> БНСУ-ын КОЙКА олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	- Худалдан авах ажиллагааны чиглэлээр 15 албан хаагчийг БНСУ-д сургалтад хамруулан туршлага судлуулж, чадавхижуулах ажлыг зохион байгуулах, - XI сард.	Худалдан авах ажиллагааны чадавхи дээшилнэ.	ЗХЗХ, ХААХ
<b>Арга хэмжээ 7.14.45.</b> Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах	- Төлөвлөгөө боловсруулан төсөлд албан хаагчдаас санал авч, батлах, IX сард, - Хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, IX-XII сард, - АТГ, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, - Төлөвлөгөөний хэрэгжилт, Авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг гаргаж, АТГ-т хуулийн хугацаанд хүргүүлэн үнэлгээнд материал бүрдүүлж өгөх, XI сард.	Авлига, ашиг сонирхлын зөрчил гараагүй байна. Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлүүлсэн байна.	ЗХЗХ, Бүх хэлтэс, алба
<b>Арга хэмжээ 7.15.46.</b> Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой холбогдох хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилтийг хангаж, мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулах	- Холбогдох мэдүүлэг, мэдэгдлийг албан хаагчид, төрийн өмчит аж ахуйн нэгж, ТӨҮГ-ын удирдлагуудаас хүлээн авч цахим системд бүртгэн, шаардлагатай бүртгэл, мэдээллийн сан үүсгэх, - 2016 оны мэдүүлэг, мэдэгдэл бүрдүүлэлтийн ажилд урьдчилан бэлтгэх, - ЭБАТ-уудын судалгаа гаргаж, сургалт зохион байгуулах, - Мэдүүлэг гаргагчдын нэрсийн жагсаалтыг тодорхой болгох арга хэмжээ авах, - IX-XII сард.	Авлигын эсрэг, хууль тогтоомж, журам, заавар хэрэгжиж, тайлан, мэдээлэл холбогдох байгууллага, албан тушаалтанд хуулийн хугацаанд хүргэгдсэн байна.	ЗХЗХ
<b>Арга хэмжээ 7.16.47.</b> Дээд шатны байгууллагаас батлан гаргасан холбогдох бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, тайлагнан мэдээлэх	- Тогтоол, шийдвэрийн хяналтад авсан заалтын судалгааг нарийвчлан гаргах, - Шинээр ирсэн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангах, - Хэлтсүүдээс холбогдох шийдвэрийн хэрэгжилтийн тайлан, мэдээллийг авч, нэгтгэн боловсруулах, - Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан журмыг хэрэгжүүлж, тогтоосон хугацаа, хуваарийн дагуу дээд шатны байгууллагад тайлагнан мэдээлж ажиллах, - Цахим систем, дотоод сүлжээгээр олон нийт, албан хаагчдад мэдээлэх, тухай бүр, - XII/15-нд.	Байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай холбогдох бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл дээд шатны байгууллага, иргэд, олон нийтэд ил тод мэдээлэгдэнэ.	ЗХЗХ, Бүх хэлтэс, алба
<b>Арга хэмжээ 7.17.48.</b> Газрын хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг	- Ажил хэрэгч шийдвэрүүдийг хяналтад авах, - Хэлтсүүдээс тайлан мэдээллийг авч, хэрэгжилтийг тооцох, - Газрын хуралдаан болон удирдлагад танилцуулах,	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудлаарх хууль, тогтоомжийн хэрэгжилт	ЗХЗХ, Бүх хэлтэс, алба

ТООЦОХ	<ul style="list-style-type: none"> <li>- Хэрэгжилтийн явцыг олон нийтэд мэдээлэх,</li> <li>- XII/20-нд.</li> </ul>	хангагдана.	
<b>ХӨТӨЛБӨР ҮИИ</b>			
<b>“Хүний нөөцийн чадавхийг сайжруулж, хэлтэс, албан хаагчдын гүйцэтгэл, үр дүнг дээшлүүлэх, сахилга, хариуцлагыг өндөржүүлэх” хөтөлбөрийн хүрээнд:</b>			
<p><b>Арга хэмжээ 8.1.49.</b> Байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгж бүр улирлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж, улирлаар ажлаа тайлагнан мэдээлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хэлтсүүд ажлаа төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг хангах,</li> <li>- Хэлтсийн ажлын гүйцэтгэл, үр дүнг журамд заасан хугацаанд тайлагнан мэдээлэх,</li> <li>- Байгууллагын цахим хуудас, дотоод сүлжээгээр дамжуулан ажлаа сурталчлан мэдээлэх,</li> <li>- Албан хаагч бүр сар бүрийн ажлын төлөвлөгөөг нэгжийн даргаар батлуулан хэрэгжилтийг тайлагнаж ажиллах,</li> <li>- XI-XII сард.</li> </ul>	Байгууллага, хэлтсийн ажлын үйл ажиллагааны үр дүн сайжирч, мэдээллийн ил тод байдал хангагдана.	ЗХЗХ, Бүх хэлтэс, алба
<p><b>Арга хэмжээ 8.2.50.</b> Албан хаагчдын ажил үүргийн хуваарийг боловсруулан батлуулж, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын хэсэг байгуулах,</li> <li>- Агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөртэй уялдуулан ажил үүргийн хуваарийг боловсруулан батлуулах,</li> <li>- Ажил үүргийн хуваарийн дагуу нийт ажлын байрны тодорхойлолтыг нарийвчлан боловсруулж, батлуулах,</li> <li>- Албан хаагчдад танилцуулах, цахим хуудсанд байршуулах,</li> <li>- X сард.</li> </ul>	Албан хаагчдын ажлын ачаалал, хуваарилалт тодорхой болно. Байгууллага, хэлтсийн ажлын үр дүн, гүйцэтгэлд тавих хяналт сайжирна.	ЗХЗХ, Ажлын хэсэг
<p><b>Арга хэмжээ 8.3.51.</b> Нийт албан хаагчидтай 2016 оны үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ байгуулж, гүйцэтгэл, үр дүнг дүгнэх ажлыг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн албан хаагчидтай ҮДГ, хөдөлмөрийн гэрээ байгуулах,</li> <li>- Шууд удирдах нэгжийн дарга тухайн албан хаагчийн үр дүнгийн гэрээг батлах, IX сард,</li> <li>- Албан хаагчдын үр дүнгийн гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулах, XII сард</li> <li>- Үр дүнгийн гэрээг дүгнэж, түүний мөрөөр авах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэх.</li> </ul>	Албан хаагчдын хариуцлагын тогтолцоо сайжирч, гүйцэтгэлийн үр дүнг хянах боломжтой болно. Байгууллагын стратегийн зорилт хангагдана.	Бүх хэлтэс, алба
<p><b>Арга хэмжээ 8.4.52.</b> Нийт албан хаагчдыг соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, байгууллагын соёлыг хэвшүүлэх арга хэмжээ авах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Ёс зүй, харилцааны болон байгууллагын соёлтой холбоотой сэдэв, агуулгатай байх,</li> <li>- Мэргэжлийн сургалтын байгууллага, лекторуудтай холбогдож, хамтрах,</li> <li>- Сургалтын товыг гаргаж, нийт албан хаагчдыг хамруулах,</li> <li>- Зохион байгуулалтад хэлтэс бүрийн оролцоог хангах,</li> <li>- Сар бүр.</li> </ul>	Байгууллагын соёл төлөвшинө. Албан хаагчдын чадавхи дээшилнэ.	ЗХЗХ, Бүх хэлтэс, алба
<p><b>Арга хэмжээ 8.5.53.</b> Ёс зүйн хороог байгуулан, албан</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Албан хаагчдын саналд үндэслэн байгууллагын Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг байгуулах,</li> </ul>	Албан хаагчдын Ёс зүйн байдалд гарсан аливаа асуудлыг	ЗХЗХ

хаагчдын Ёс зүйн дүрмийг боловсруулан мөрдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Ёс зүйн хорооны ажиллах журам, албан хаагчдын Ёс зүйн дүрмийн төслийг боловсруулан албан хаагчдын саналыг тусган батлах,</li> <li>- Ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,</li> <li>- XI-XII сард.</li> </ul>	шийдвэрлэх боломж бий болно.	
<b>Арга хэмжээ 8.6.54.</b> Байгууллагын нийт ажилтнуудад холбогдох эрх зүйн туслалцааг үзүүлж, зөвлөгөө, мэдээллээр хангах, хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Шаардлагатай эрх зүйн туслалцаа үзүүлэх,</li> <li>- Тухай бүрд.</li> </ul>	Албан хаагчид хариуцсан ажлын чиглэлээр хууль, эрх зүйн зөрчилгүй ажилласан байна.	ЗХЗХ
<b>Арга хэмжээ 8.7.55.</b> Нийт албан хаагчдад шинээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм, журмын талаар мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Ажилтнуудад шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгөх,</li> <li>- Дагаж мөрдөх дүрэм, журмыг танилцуулж, тайлбарлах,</li> <li>- XI-XII сард.</li> </ul>	Албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг дээшилнэ.	ЗХЗХ
<b>ХӨТӨЛБӨР IX</b>			
<b>“Мэдээллийн технологийн ололтыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх замаар менежментийг сайжруулах” хөтөлбөрийн хүрээнд:</b>			
<b>Арга хэмжээ 9.1.56.</b> Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн хэвийн үйл ажиллагааг хангаж, худалдан авах ажиллагааны үйл явцад мониторинг хийх	<ul style="list-style-type: none"> <li>- Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах боломж, нөхцлийг хангах,</li> <li>- Орон нутгийн нэгжийг чадавхижуулах,</li> <li>- ААНБ-уудыг чадавхижуулах,</li> <li>- Мэдээллийн санд мониторинг хийж, зөвлөмж өгөх,</li> <li>- Тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж байгаа байдалд хяналт тавих,</li> <li>- IX-XII сард.</li> </ul>	Цахим худалдан авах ажиллагааны үр дүн олон нийтэд ил тод мэдээлэгдэнэ.	MTA
<b>Арга хэмжээ 9.2.57.</b> Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн дэд системүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Дэд систем бүрийн ашиглалтыг нэмэгдүүлэх,</li> <li>- Худалдан авах ажиллагааны мэдээллийн санг боловсронгуй болгосон байх,</li> <li>- Цахим худалдан авах ажиллагааны чадавхийг сайжруулах арга хэмжээ авах,</li> <li>- IX-XII сард.</li> </ul>	Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем улсын хэмжээнд хэрэгжинэ. Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийн бааз үүсч, ил тод байдал хангагдана.	MTA
<b>Арга хэмжээ 9.3.58.</b> Төрийн өмчийн мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг хангаж, сайжруулах, боловсронгуй болгох, мэдээллийн технологийн аюулгүй байдал, нууцлалыг хангах	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчийн мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг хангах,</li> <li>- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн хөрөнгийн бүртгэлийг цахим системд оруулах боломжоор хангах,</li> <li>- Төрийн өмчийн мэдээллийн системийн цаашдын хөгжил, чиг хандлагыг судлан санал боловсруулах,</li> <li>- IX-XII сард.</li> </ul>	Цахим мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг хангаснаар төрийн өмчийн бүртгэл, тооллого явуулах үйл ажиллагаа хурдан, шуурхай, үр ашигтай, хэмнэлттэй байх нөхцөл хангагдана.	MTA

<p><b>Арга хэмжээ 9.4.59.</b> Байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, албан хаагчдад мэдээллийн технологийн орчин үеийн ололтыг ашиглахад чиглэсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын дотоод болон гадаад сүлжээний хэвийн ажиллагааг хангах,</li> <li>- Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангахад чиглэсэн сувгийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах,</li> <li>- Төрийн байгууллагын цахим шуудан <a href="http://www.webmail.gov.mn">www.webmail.gov.mn</a> -ийн хэвийн үйл ажиллагааг хангах, зааварчилгаа өгөх,</li> <li>- Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн боловсруулж, хөгжүүлэлт хийх,</li> <li>- IX-XII сард.</li> </ul>	<p>Байгууллагын дотоод болон гадаад сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.</p>	<p>МТА</p>
<p><b>Арга хэмжээ 9.5.60.</b> Албан хэрэгцээнд дотоод сүлжээний <a href="http://www.able.mn">www.able.mn</a> e-office системийн хэрэглээг сайжруулж, албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг дээшлүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Удирдлагын мэдээллийн нэгдмэл байдал хангагдах нөхцөл бүрдэж, дотоод хяналт сайжирах,</li> <li>- Ажлын уялдаа холбоо сайжирч, бүтээмж дээшилсэн байх,</li> <li>- Цаг бүртгэлийн төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж, цаг ашиглалтад тавих хяналтыг дээшлүүлэх,</li> <li>- IX-XII сард.</li> </ul>	<p>Албан хаагчдын ажлын бүтээмж, гүйцэтгэлд ахиц гарсан байна. Гүйцэтгэлд тавих хяналт сайжирна.</p>	<p>МТА, Бүх хэлтэс, алба</p>
<p><b>Арга хэмжээ 9.6.61.</b> Байгууллагын хяналтын камер, хурлын өрөөний техник, тоног төхөөрөмжийн хэвийн жигд үйл ажиллагааг хангах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах.</li> <li>- IX-XII сард.</li> </ul>	<p>Байгууллагын үйл ажиллагаа, дэг журам, сахилга, хариуцлага өндөржинө.</p>	<p>МТА</p>
<p><b>ХӨТӨЛБӨР Х</b> <b>“Байгууллагын дотоод зохион байгуулалтыг сайжруулж, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах” хөтөлбөрийн хүрээнд:</b></p>			
<p><b>Арга хэмжээ 10.1.62.</b> Албан хаагчдын албан тасалгаа, нэг цэгийн үйлчилгээний танхим, компьютерийн лаборатори, үнэлгээний хорооны хурлын танхим, бичиг хэргийн өрөөний зохион байгуулалтийг хийж, хэвийн жигд ажиллагааг хангах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Өрөөний хуваарилалт, зохион байгуулалтыг хийж, тоног төхөөрөмжийг суурилуулах, засвар тохижилтыг хийх,</li> <li>- Өрөө, танхимын хаяг, дугаартай болгох,</li> <li>- Албан хаагчдын өрөө, утасны дугаарыг нэгтгэн гаргаж, тараах,</li> <li>- Зарим тохижилт, засварын ажлыг гүйцэтгэж, байгууллагын гадна, дотор байрлах хаягийг хийлгэж байрлуулах,</li> <li>- IX-X сард.</li> </ul>	<p>Байгууллагын угтах үйлчилгээ, иргэдэд үйлчлэх үйлчилгээ хэвийн явагдаж эхэлсэн байх</p>	<p>ЗХЗХ, ХААХ, МТА</p>
<p><b>Арга хэмжээ 10.2.63.</b> Нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж ажиллах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Нэг цэгийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн аж ахуйн нэгжүүдэд өмчийн харилцаа болон тендертэй холбоотой мэдээ, мэдээллийг ил тод түргэн шуурхай хүргэх, цахим тендерт бүртгэх,</li> <li>- Бүртгэл тоо, баримт, мэдээлэлд анализ хийж, холбогдох газар, албан тушаалтанд мэдээлэх,</li> <li>- Сар бүр.</li> </ul>	<p>Олон нийттэй харилцах харилцаа, мэдээлэл, лавлагааны үйлчилгээ нэг цэгт төвлөрч, иргэдэд чирэгдэлгүй, шуурхай үйлчлэх боломж бий болно.</p>	<p>ЗХЗХ</p>
<p><b>Арга хэмжээ 10.3.64.</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хурлын бэлтгэлийг хангах, хурлын зар, хэлэлцэх</li> </ul>	<p>Хурлын зохион байгуулалт</p>	<p>ЗХЗХ</p>

Газрын хуралдаан болон бусад хурлын бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хангаж ажиллах	асуудалтай холбоотой мэдээлэл, гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг бэлтгэх, холбогдох хүмүүст хүргэх, - Хурлын тэмдэглэл хөтөлж, албажуулах, - IX-XII сард.	хэвшиж, байгууллагын соёл төлөвшинө.	
<b>Арга хэмжээ 10.4.65.</b> Байгууллагын албан хаагчид болон төрийн өмчит хувьцаат компани, ТӨҮГ-ын Гүйцэтгэх захирал, захирал нарт албан үнэмлэх олгох ажлыг зохион байгуулах	- Үнэмлэхжүүлэхэд гарах зардлын тооцоог гаргаж шийдвэрлүүлэх, - Албан үнэмлэхийн загвар гарган батлуулж, хэвлүүлэх, - Үнэмлэх олгох ажлыг гүйцэтгэх, - XI сард.	Байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдал хангагдаж, байгууллагад нэвтрэх эрх бүхий этгээдийн нэвтрэх боломж нөхцөл хялбаршсан байна.	3Х3Х
<b>Арга хэмжээ 10.5.66.</b> Татан буугдсан байгууллага (ХААГ)-ын архивыг өмнө ажиллаж байсан албан хаагчдаас бүрэн хүлээн авах ажлыг зохион байгуулан хуулийн дагуу Архивын ерөнхий газарт хүлээлгэн өгөх	- Ажлын хэсэг байгууллах, төлөвлөгөөтэй ажиллах, - Ажлын хэсгийн дүгнэлт гаргах, - Архивын хадгаламжийн нэгжүүдийг хүлээлгэж өгөх бүртгэл, дансыг бэлтгэх, - Архивын Ерөнхий газарт хүлээлгэж өгөх, - XI сард.	Байгууллагын архивын бүрдүүлэлт, бүртгэл, данс бүрэн хөтлөгдөж, архивын нэгжийн баяжилт хийгдсэн байна. Татан буугдсан байгууллагын архивын нэгжүүд Төрийн архивт шилжсэн байна.	3Х3Х
<b>Арга хэмжээ 10.6.67.</b> Байгууллагад ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн ажлыг зохион байгуулах	- Албан бичгийн шийдвэрлэлтэд <a href="http://www.able.mn">www.able.mn</a> дотоод сүлжээгээр дамжуулан хяналт тавих, - Хугацаатай албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулах, - Шийдвэрлэгдээгүй албан бичгийн мэдээг удирдлагад гаргаж танилцуулан шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллах, - Сар бүр.	Байгууллагын албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн стандарт, заавар журмын хэрэгжилт хангагдсан байна.	3Х3Х
<b>Арга хэмжээ 10.7.68.</b> Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан, шийдвэрлэх асуудлаар санал боловсруулах	- Өргөдөл, гомдлыг судлан шийдвэрлэх арга замыг тодорхойлох, - Шийдвэрлэх саналыг боловсруулан удирдлагад танилцуулж шийдвэрлүүлэх, - Холбогдох иргэн, байгууллагад шийдвэрлэсэн хариуг хүргүүлэх, - Байгууллагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн судалгаанд хамруулах - Сар бүр.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	3Х3Х, Бүх хэлтэс, алба
<b>Арга хэмжээ 10.8.69.</b> Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг хууль тогтоомжид нийцүүлэн явуулж, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах	- Тухайн сард гарах холбогдох гүйлгээнүүдийг хийх, - Албан хаагчдын цалинг сард бодож олгох, - Шилэн дансны бүртгэлийг шинээр нээлгэх, - Шилэн дансны мэдээллийн самбарыг шинэчлэх.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, байгууллагын төсөв, санхүүгийн мэдээллийн ил тод байдал хангагдана.	3Х3Х

<p><b>Арга хэмжээ 10.9.70.</b> 2017 оны төсвийн төлөвлөгөөг Сангийн яаманд хянуулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төсвийн төлөвлөлттэй холбоотой шаардлагатай баримт материалыг бэлтгэх,</li> <li>- 2017 оны төсвийн төслийг Сангийн яам, Ерөнхий сайдын ажлын албанд хүргүүлэх,</li> <li>- IX сард.</li> </ul>	2017 оны төсөв хянагдсан байна.	ЗХЗХ
<p><b>Арга хэмжээ 10.10.71.</b> Сар бүрийн 05-ны өдрийн дотор нийгмийн даатгалын тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг гаргах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох тайланг Нийгмийн даатгалын байгууллага, Ерөнхий сайдын нягтланд хүргүүлэх,</li> <li>- Нийгмийн даатгалд бүртгүүлж, гэрчилгээ авах,</li> <li>- Сар бүрд.</li> </ul>	Нягтлан бодох бүртгэлийн хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт шаардлагад нийцсэн тайлан тэнцлийг гаргаж, цаг хугацаандаа хүргэгдсэн байна.	ЗХЗХ, Ахлах нягтлан бодогч Б.Мөнхзул
<p><b>Арга хэмжээ 10.11.72.</b> Эд хөрөнгийн бүртгэлийг шинэчлэх, Сангийн яамнаас ирсэн тавилга, тоног төхөөрөмжийг баланс хооронд шилжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Эд хөрөнгийн бүртгэлийг шинэчлэх,</li> <li>- Албан хаагч бүрт эд хөрөнгийн бүртгэл, ашиглалтын карт нээх,</li> <li>- XI-XII сард.</li> </ul>	Эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд тавих боломж бүрдэнэ.	ЗХЗХ, Нярав С.Цэрэндорж
<p><b>Арга хэмжээ 10.12.73.</b> Санхүүгийн бүртгэлийн программыг шинэчлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн программыг шинэчлэх,</li> <li>- Хэвийн ажиллуулах боломжтой болгох, ашиглалтад хүлээн авах,</li> <li>- IX сард.</li> </ul>	Санхүүгийн программыг ашиглаж эхэлсэн байна.	ЗХЗХ, Ахлах нягтлан бодогч Б.Мөнхзул
<p><b>Арга хэмжээ 10.13.74.</b> Байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангахад шаардлагатай бараа, материалыг татан авч, хуваарилах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Албан бичгийн хэвлэмэл хуудас, дугуйг шинээр захиалж хийлгэх,</li> <li>- Цэвэрлэгээ үйлчилгээ, бичиг хэргийн бараа материалыг захиалж, хангалт хийх, нийлүүлэгчтэй холбогдох хууль, журамд заасны дагуу гэрээ хийх,</li> <li>- Бараа, материалын татан авалт, хангалт, хуваарилалт хийх,</li> <li>- Төсөв, тооцоог удирдлагад танилцуулах,</li> <li>- IX-X сард.</li> </ul>	Байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдана.	ЗХЗХ, Нярав С.Цэрэндорж
<p><b>Нийт: 10 хөтөлбөр, 74 арга хэмжээ</b></p>			

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАВАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:  
ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДОТООД АЖИЛ,  
ТАЙЛАН ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ